

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

## ЭРДЭМ ШИНЖИЛГЭЭНИЙ БИЧИГ

№19/496

ШУС, НУС

2018

### ТЕЛЕВИЗИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН НЭВТРҮҮЛЭГТ ХИЙСЭН ЗАРИМ АЖИГЛАЛТ

Д.Ариунцэцэг\*

\*МУИС-ийн Шинжлэх ухааны сургуулийн Нийгмийн ухааны салбарын Сэтгүүл зүй, олон нийтийн харилцааны тэнхимийн докторант

**Түлхүүр үг:** эрүүл мэндийн сэтгүүл зүй, шинжлэх ухааны сэтгүүл зүй, телевизийн сэтгүүл зүй, телевизийн нэвтрүүлэг, эрүүл мэндийн нэвтрүүлэг, сэтгүүлчийн ур чадвар, сэтгүүлчийн ёс зүй, хариуцлага.

**Х**үний эрүүл мэнд гэдэг юугаар ч хэмжигдэшгүй хамгийн үнэтэй, эрхэм баялаг юм. Гагцхүү бие бялдар, сэтгэл санааны хувьд эрүүл хүн л алдар нэрийг олж, эд баялгийг бүтээж, амжилтыг гартаа атгаж чадна. Техник технологийн зуун, даяаршлын эрин үед дэлхийн улс орнууд хүмүүн капиталыг хөгжлийн жолоодогч хэмээн нэгэнт хүлээн зөвшөөрч, агаар, ус, хоол хүнсний аюулгүй байдал зэрэг хүний эрүүл мэндийг сахин хамгаалах олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлсээр байна. Манай улсын хувьд ч хүн амын бодлогын чухал хэсэг нь эрүүл мэндэд чиглэсэн байх ёстой юм. Өөрөөр хэлбэл хөгжлийн түлхүүрийг хүн, тэр дундаа эрүүл хүн гэж үзвэл нийгмийн нүд чих болсон сэтгүүл зүйн салбарын хамгийн тэргүүлэх чиглэлүүдийн нэг нь эрүүл мэндийн сэтгүүл зүй мөн гэж хэлж болно.

Мэдээллийн ач холбогдол эрс өсөн нэмэгдэж, энерги, матери хэмээх ойлголтуудтай адилтган үздэг болсон

орчин үед нийгмийн амьдралыг сэтгүүл зүй түүний мэдээлэлгүйгээр төсөөлөх боломжгүй юм. Сэтгүүл зүй нийгмийн олон салбарт өөрийн үүргээ гүйцэтгэсээр хүн төрөлхтнийг өнөөгийн хөгжил дэвшилд авчирсан. Тэдгээрийн нэг болох эрүүл мэнд, анагаах ухааны хөгжил дэх сэтгүүл зүйн мэдээллийн ач холбогдлыг үнэлж баршгүй юм. Сэтгүүл зүйн эмчийн нэгэн адил амьдралын судсыг барьж, нийгэмд онош тавихын хамт шаардлагатай гэж үзвэл "эмчлэх" эмчилгээний стратеги тактикийг тодорхойлдог.<sup>1</sup> Тэр ч утгаараа энэ хоёр мэргэжил хүний сайн сайхны төлөө зорилго нэгддэг.

Эрүүл мэнд, өвчин эмгэг, эрүүлийг хамгаалах салбар болон эм, бэлдмэлийн сэдвийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тусгайлан хөндөж, олон нийтэд хүргэх зорилго бүхий сэтгүүлчийн үйл ажиллагааг эрүүл мэндийн (Health journalism reporting), анагаах ухааны (Medical journalism reporting) сэтгүүл зүйн аль алинаар нь нэрлэдэг ч анагаах ухааны сэтгүүл зүй гэсэн нэр томъёог ашиглах нь олон улсад түгээмэл байдаг. Гэхдээ энэ сэтгүүл зүй нь зөвхөн эмнэлэг, анагаах ухааны асуудлаар хязгаарлагддаггүй учраас эрүүл мэндийн сэтгүүл зүй гэдэг

нэр томъёо нь амьдралд хавьгүй ойр юм.

Тусгай нэр томъёо, шинжлэх ухаан, түүний дотор анагаах ухааны мэргэжлийн хэллэг ихээхэн ашигладаг болохоор эрүүл мэндийн сэтгүүл зүйг шинжлэх ухааны сэтгүүл зүй (Science journalism reporting)-н бүрэлдэхүүн хэсэг ч гэж үздэг байна.

Анх 1960-аад оноос хойш радио болон телевизийн нэвтрүүлэгт эмнэлгийн тусгай нэвтрүүлгийг бий болгож улмаар ЗХУ болон бусад социалист орнуудын туршлагаар Ариун цэвэр гэгээрлийн ордны арга зүйн тасагт радио, телевиз, хэвлэлийн эрүүлийг хамгаалахын сурталчилгааг хариуцсан арга зүйч их эмчийг ажиллуулах болсон байна. Энэ сурталчилгааны арга зүйч их эмч нь радио телевизээр нэвтрүүлж, хэвлэлд нийтэлж байх эмчийн зөвлөгөө ба эрүүлийг хамгаалахын бусад материалыг хянах, сурталчилгааг цаг үе, эрүүлийг хамгаалахын тулгамдсан ба хэтийн бодлоготой уялдуулах, судалгаа шинжилгээ хийх үүрэгтэй байжээ.<sup>2</sup> Үүнээс үзэхэд тухайн салбарын гарцаагүй үнэн бодит байх, шинжлэх ухааны тодорхой стандарт, хэм хэмжээтэй байх шаардлагатай уялдуулан төр засгаас онцгойлон анхаарч, мэргэжлийн тусгай эмчийг томилон, ард олонд эрүүл мэндийн боловсрол эзэмшүүлэх үйл ажиллагааг бодлоготойгоор зохион байгуулдаг байж. Ингэснээр хүн ам эрүүл энх, урт насалж, улмаар хөдөлмөрийн чадвар нь хэвээр байснаар эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх боломжтой гэсэн тухайн үеийн социалист нийгмийн улс төрийн бодлоготой ч нягт уялдаж байсан юм.

Телевиз нь дуу авиа, дүрс тэмдэгт, текст зэрэг харилцааны бүхий л элементийг зэрэг ашиглан мэдээлэл

хүргэдгээрээ бусад хэвлэл мэдээллийн хэрэгслийг бодвол итгүүлэн үнэмшүүлэх чадвараараа хамгийн өндөр юм. Тухайн мөч, давуу чанар, нэвтрэх чадвар гэсэн гурван ойлголтоор телевизийн өвөрмөц онцлогийг тодорхойлж болно.<sup>3</sup> Түүний шуурхай байдал нь тухайн мөч гэсэн ойлголтыг тайлбарлаж болно. Харин телевизийн нөлөөлөх (нэгэн зэрэг уншина, сонсоно, үзнэ) чадвар нь давуу байдлыг илтгэнэ. Мэдээлэл нь нэг мөчид нэгэн зэрэг олон хүнд хүрдэг нь телевизийн нэвтрэх чадвартай шууд холбогддог. Иймд радио, сонин, сэтгүүлээс илүү телевизээр дамжуулан олон нийтэд эрүүл мэндийн боловсрол олгох, мэдээ, мэдээлэл хүргэх нь өндөр ач холбогдолтой юм.

**И**ргэдийн дунд хийсэн судалгаанаас харахад телевиз болон интернетээс эрүүл мэндийн мэдээ, мэдээллийг илүү хүлээн авдаг гэсэн байна. Тусгайлсан нийтлэлийн бодлого, редакци, сэтгүүлч, баг хамт олноороо мэргэжлийн өндөр түвшинд мэдээ мэдээллийг бэлтгэн хүргэдгийн хувьд телевиз баттай эх сурвалж, үнэн бодит байдлаараа интернетээр түгэж буй контенттой харьцуулшгүй давуу юм. Тиймээс энэ давуу чанартаа тулгуурлан чанартай, сонирхолтой, хүнд хэрэгтэй нэвтрүүлэг бэлтгэн хүргэх нь манай өнөөгийн телевизүүдийн бас нэгэн сорилт байх ёстой.

Үндэсний хэмжээнд хүрдэг, өргөн нэвтрүүлгийн голлох 8 телевизийн эрүүл мэндийн нэвтрүүлэгт ерөнхий тойм ажиглалт хийж, тэдгээрээс үзэгчдийн дунд танил болсон, эфирээр тогтмол давтамжтай хүрдэг VTV-ийн “Ай ёо доктор”, MN25-ийн “Ёо ёог анагаах нь”, МҮОНТ-ийн 120:80 нэвтрүүлгүүд дээр нарийвчилсан анализ хийлээ.

Телевизийн эрүүл мэндийн нэвтрүүлгүүдийн судалгаа (7 хоногоор 2018.03.25-04.01)

№	ТВ нэр	Нэвтрүүлгийн нэр	Гараг-цаг	Давтамж
1	МҮОНТ	120/80	Ням-13:00-14:00	1
2	UBS	Эрхэм баян-Эрүүл мэнд	Ням-20:30 Даваа-12:10 Лхагва-20:30 Бямба-12:30	4
3	MN-25	Ёо ёог-анагаах нь	Ням-10:25 Лхагва-21:30 Бямба-10:25	3
4	TV5	Цахим эмч	Ням-18:00 Даваа-10:20	2
		Эрүүл амьдарцгаая	Мягмар-14:20	1
5	TV9	Эрүүл мэнд	Пүрэв-15:40	1
6	C1	Эрүүл ирээдүй	Өдөр бүр 11:00	7
7	TV8	Амьдрах ухаан-иогийн дасгал	Лхагваас бусад өдөр-07:25	6
8	ETV	Эрүүл амьдрал	Даваа-14:00	1
9	VTV	Ай ёо доктор 54:34, 48:30	Ням-20:00 Даваа-12:00, 17:00	2

Эндээс харахад VTV-ийн “Ай ёо доктор”, MN25-ийн “Ёо ёог анагаах нь”, МҮОНТ-ийн 120:80 зэрэг нэвтрүүлгүүд долоо хоногийн бямба, ням гаригуудад, бусад нь “Эрүүл мэнд”, “Эрүүл ирээдүй”, “Эрүүл амьдарцгаая” гэх мэт ерөнхий агуулгыг хадгалсан нэрээр амралтын биш өдрүүдээр гарч байна. Хэлбэр агуулгын хувьд төдийлэн хүртээмжтэй биш байдлаар бэлтгэгдсэн богино хэмжээний контентийг өдөр бүр, бүр өглөө эрт гаргадаг телевиз байхад, сонирхолтой сэдэв агуулгаар, нэлээд даацтай байдлаар долоо хоногт нэг удаа (хүмүүсийн гэртээ байж үзэх боломжтой цагаар) нэвтрүүлдэг телевиз ч байна. Түүнчлэн ЭМЯ-наас захиалан хийлгэдэг Эрүүл мэнд-эрхэм баян нэвтрүүлгийг телевизүүд эфирийн цагаараа хүргэж байна. Судалгаанд хамруулж авч үзсэн дээрх телевизүүдийн тухайн өдрийн эфирийн нийт цагийн 5 хүрэхгүй хувийг л эрүүл

мэндийн нэвтрүүлэг эзэлж байгаа нь туйлын чамлалтай үзүүлэлт юм.

Хүмүүст амралтын өдрүүдэд илүү чөлөөт цаг гарч, телевиз үзэх, өөрт хэрэгтэй мэдээ мэдээллийг олж авах боломж олддог. Гэтэл судалгаанд тусгайлан сонгосон 3 телевизээс бусад нь даваагаас баасан гаригуудад өдрийн цагаар л нэвтрүүлгээ хүргэж байгаа нь хүртээмж, үр нөлөөг шууд бууруулж буй хэрэг юм.

МҮОНТ-ийн 120/80 эрүүл мэндийн нэвтрүүлэг нь долоо хоногийн бямба, ням гаригийн аль нэг өдрийн их үдийн 13:00-14:00 цагийн үед гардаг бөгөөд сэтгүүлч, мэргэжлийн эмч ээлжлэн хөтөлдөг. Давтамжийн хувьд 7-14 хоногт нэг удаа гарах ба дунджаар 40-45 минут үргэлжилдэг. Нэвтрүүлэгт тухайн сэдэвтэй холбогдуулан нэг ба нэлээд хэдэн хүн студид урин оролцуулдаг. Зочид нь гол төлөв мэргэжлийн эмч нар байх ба заримдаа

ямар нэгэн эмчилгээний үр дүнг хүртсэн энгийн иргэн ч оролцдог.

MN 25-ийн “Ёо ёог анагаах нь” нэвтрүүлэг нь долоо хоногийн бямба, ням гаригийн тогтмол 10:25 минутанд үзэгчдэдээ хүрдэг. Энэ нь хүртээмжийг нэмэгдүүлэхэд, бусдад танил болоход чухал нөлөөтэй. Багцалсан хэд хэдэн сэдвийг хөндсөн тохиолдолд нэг цаг орчим харин тодорхой нэг л сэдвийн тухайд 25 орчим минут нэвтрүүлэг үргэлжилдэг. Голдуу мэргэжлийн сэтгүүлч, хөтлөгч удирдан хүргэдэг энэ нэвтрүүлгийн хувьд аливаа нэг сэдвийн талаар мэргэжлийн эмчтэй харилцан ярилцах хэлбэрээр явдаг.

**Д**ээрх хоёр нэвтрүүлгийн хувьд ижил тал нь мэргэжлийн зочин оролцуулж, мэдээлэл хүргэдэг бол ялгаатай тал нь МҮОНТ тухайн нэг л сэдвийн хүрээнд олон эх сурвалжаас мэдээлэл авснаар тэнцвэртэй байдлыг хадгалахыг зорьдог бол MN25-ийн хувьд нэг ба хэд хэдэн сэдвийг нэг удаагийн нэвтрүүлгээр багтаадаг ба сэдэв тус бүрт нэг л эх сурвалжийг голчилдог. Мөн хоёулаа нэвтрүүлгийн дундуур кэйс болгон жүжигчилсэн зохиомж, шинжлэх ухааны хялбаршуулсан видео бичлэг оруулдаг ба МҮОНТ-ийн хувьд үзүүлэн, зурагт тайлбар түлхүү ашигладаг.

VTV-ийн “Ай ёо доктор” нэвтрүүлэг нь долоо хоногийн ням гаригийн 20:00 цагт тогтмол үзэгчдэд хүрдэг нь хамгийн оргил цагтай давхацдаг учир тухайн сувгийг сонгосон хүн бүр үзэх магадлалтай. Үүгээрээ уг нэвтрүүлэг хүртээмжийн хувьд өндөр юм. Даваа гаригт нь 12:00, 17:00 цагуудад мөн давталт нь гардаг. “Шүлтлэг ба хүчиллэг хоол” сэдвээр 2015 оны 12-р сарын 15-нд анхны дугаараараа үзэгчидтэйгээ уулзаж байсан энэ нэвтрүүлэг өдийг хүртэл

тасралтгүй гарч ирсэн бөгөөд бусдаас нэлээд ялгарах онцлогтой. Өөрөөр хэлбэл анитэйшин, дуу бүхий өвөрмөц эхлэл, шийдэл, зохиомжтой уг нэвтрүүлгийн Ай ёо доктор (эмч) нь өөрөө гол цөм бөгөөд Баагий хөтлөгч, Түшка туслах ажилтныхаа хамт олон нийтэд эрүүл мэндийн боловсрол түгээдэг. Хугацааны хувьд жаахан урт (дунджаар 50 минут) боловч бүтэц, зохиомж хэлбэрийн хувь сонирхолтой, мэдээллийн багтаамж сайн, танин мэдэхүйн өндөр ач холбогдолтой нэвтрүүлэг юм. Анагаахын нэр томъёог энгийн хэллэгт оруулж тайлбарладаг. Тухайлбал, мэргэжлийн хэлээр эстэмцел гэдгийг хүн анх төрөхөд нь хүйнд байх үүдэл эс гэж тайлбарласан бөгөөд үүнээс хүний бүх эрхтнийг шинээр дахин ургуулж болдгийг хэлж байх жишээтэй. Түүнчлэн илүү сонирхолтой болон итгэл үнэмшилтэй болгохын тулд нэвтрүүлгийн дундуур Ай ёо доктор өөрөө бодит үзүүлэн авчирч, түүн дээрээ жишээ болгон тайлбарладаг. Тухайлбал, хүний тархины элдэв өвчний учир шалтгааныг хонины тархин дээр, үүдэл эсийн тухай хүний жинхэнэ эхэс дээр микроскопоор харуулж тайлбарласан. Элэгний өвчлөлийн тухайд эрүүл болон өвчтэй элэг ямар байдгийг бодит үзүүлэн дээр тайлбарладаг нь үзэгчдэд илүү сонирхолтой болгодог. Мөн нэвтрүүлгийн тухайн сэдвээр хөтлөгч Баагий нь өөрөө өвчтөн болж шинжилгээ оношилгоогоо бодитоор хийлгэдэг. Тэр явцад эмчээр нь шинжилгээ оношилгооны талаар тайлбар аваад, учир шалтгааных нь тухайд Ай ёо доктор өөрөө жинхэнэ үзүүлэн дээр жишээ болгон харуулдаг. Нэвтрүүлгийн дундуур шинжлэх ухааны хялбаршуулсан контентийг дундаж уншигч ойлгохуйц хэмжээнд бэлтгэн хүргэдэг. Тогтмол

цагт тасралтгүйгээр, сонирхолтой хэлбэрээр хүргэдэг нь энэ нэвтрүүлгийн үзэгчдийн талархлыг хүлээх гол хүчин зүйл болсон. Мөн сэдэв сонголт, эх сурвалж, агуулга хэлбэрийн нийцэл буюу ойлгомжтой байдал нь түүний үр нөлөөг улам сайн болгож байна. Үүнд ажиглагдсан нэг дутагдалтай тал нь эм эмнэлгийн сурталчилгаа оруулдаг. Энэ нь магадгүй нэвтрүүлгийн маркетингтэй холбоотой байж болох ч үнэхээр сайн эм, эмнэлэг, эмчилгээг оновчтой сонгосон бол ашиг тустай ч хэрэв эсрэгээрээ бол маш том эрсдэл дагуулах, хариуцлагын асуудал юм. Тиймээс энэ тал дээр анхаарал болгоомжтой хандах хэрэгтэй. Бусад телевизийн эрүүл мэндийн нэвтрүүлгүүдийн хувьд ч иймэрхүү байдал түгээмэл байна.

Телевизийн эрүүл мэндийн нэвтрүүлгийг боловсронгуй болгох тухай асуудлыг ярихаас өмнө эрүүл мэндийн сэтгүүл зүй, энэ чиглэлийн сэтгүүлчдэд тавигдах үндсэн хэд хэдэн шаардлагын талаар товч дурдах нь зүйтэй. Үүнд:

Хариуцлагатай байх: Аль ч чиглэлээр бичдэг сэтгүүлч хариуцлагатай байх ёстой. Тэр дундаа эрүүл мэндийн сэдвээр бичигчээс бүр ч өндөр хариуцлагыг шаардаж байдаг. Олон улсын сэтгүүлчдийн нийгэмлэг (АНСЖ) эрүүл мэндийн асуудлыг хөндөхдөө маш анхаарал болгоомжтой хандахыг гишүүддээ байнга сануулдаг байна. Ялангуяа эм эмчилгээ, эмчийн тухай мэдээлэл өгөхдөө маш олон талын эх сурвалжтай харьцан, буурь суурьтай хандах нь хариуцлага алдахгүй байх гол үндэс. Үнэндээ эмнэлгийн бүхий л практик шинжлэх ухаанд үндэслэгддэг учраас энэ талын мэдээллийг олон нийтэд хүргэх асуудал туйлын хариуцлагатай ажил юм. Тийм ч учраас дэлхийн сэтгүүл

зүйн практикт эрүүл мэндийн сэдвээр бичдэг сэтгүүлчид тусгайлан мэргэшин, анагаах ухааны мэдлэг мэдээллээр бүрэн “зэвсэглэсэн” байхыг эрхэмлэдэг аж.

Энгийн ойлгомжтой байх: Энэ нь хүртээмжийг нэмэгдүүлэх гол шаардлага юм. Олон нийт буюу уншигч, сонсогч, үзэгчдэд эрүүл мэндийн нарийн төвөгтэй мэдээллийг энгийн ойлгомжтой үгээр хүргэх нь эрүүл мэндийн сэтгүүл зүйн гол шаардлага юм. Эрүүл мэндийн сэтгүүл зүй нь шинжлэх ухаанд илүү ойр, мэргэжлийн нэр томъёо, үг хэллэг ихээр хэрэглэдэг учраас мэдээллийг олон нийтэд түгээх гүүр болж байгаа сэтгүүлчээс өндөр ур чадвар, мэдлэг, туршлага шаарддаг.

**Ү**нэ цэнэтэй байх: “...сэтгүүл зүйн үр нөлөө зорилгын эцсийн зогсоол болох хүнд юу өгөв гэдэг талаар бага яригдаж байгаа нь нууц биш юм”<sup>4</sup> хэмээн сэтгүүл зүй судлаач, доктор Б.Болд-Эрдэнэ тэмдэглэсэн байдаг. Тийм учраас мэдээллийн үр өгөөжийн талаар илүү ярихад эрүүл мэндийн сэдэв нэн тохиромжтой байдаг. Эрүүл мэндийн мэдээлэл хүлээн авагчдын өөрийн онцлог, мэдээллийн эрэлт хэрэгцээний өвөр-мөц орчинг сэтгүүлч бодолцон үзэж, мэдээллийн боловсруулалт, илэрхий-лэл, түгээлтэнд онцгой анхаарч байх ёстой.

Олон талт байх: Орчин үед аливаа шинжлэх ухаан дан ганцаараа бус харин ойр төсөөтэй бусад салбартайгаа хоршин хөгжиж, өндөр үр дүнд хүрч байна. Үүний адилаар анагаах ухааны салбар ч хими, биотехнологи, нанотехнологи, мэдээллийн технологийн ололт амжилтанд суурилан шинэ шинэ эм болон эмчилгээний арга хэлбэрүүдийг нэвтрүүлсээр байна.

Энэ утгаараа эрүүл мэндийн сэдэв нь улам гүнзгийрэн баяжиж, бусад шинжлэх ухааны хөгжил дэвшилтэй хамтатган авч үзэх шаардлага гарсан. Нөгөө талаар эрүүл мэндийн сэтгүүл зүй нь эрүүл мэндийн харилцааг тусгадаг учраас үүнийг тодорхойлоход оролцдог нийгэм, эдийн засаг, улс төр, экологи, хууль эрх зүй, сэтгэл зүй, биеийн тамир спорт тэр бүү хэл шашин шүтлэг, далд ертөнцтэй (парапсихологи) ч харилцан хамааралтай.

#### Танин

#### мэдэхүйн ач холбогдолтой байх:

Шинжлэх ухаан ба танин мэдэхүй гэсэн ойлголтууд нэг зүйлийн хоёр тал юм. Энэ утгаараа эрүүл мэндийн сэтгүүл зүйд шинжлэх ухаанч шинж байгаа үед танин мэдэхүйн шинж салшгүй хамт байх учиртай.

#### Шинжлэх

ухаанч байх: Олон улсад эрүүл мэндийн сэтгүүл зүйг (Health journalism reporting) шинжлэх ухааны сэтгүүл зүйн (Science journalism reporting) нэг бүрэлдэхүүн хэсэг гэж үзэх хандлага байдаг нь өвчин, эм эмчилгээний хэллэг тусгайлсан нэр томъёогоор илэрхийлэгддэгтэй холбоотой. Өөрөөр хэлбэл, сэтгүүлчээс илүү шинжлэх ухаанч мэдлэг шаарддаг нь энэ чиглэлээр хүч сорьж яваа хэвлэл мэдээллийн ажилтанд том шалгуур болдог. Тиймээс ч тусгай мэргэшсэн байхыг шаарддаг. Эрүүл мэндийн

сэдэв өөртөө шинжлэх ухаан, техникийн үзүүлэлтүүдийг агуулдаг.

Хүнд өгөөжтэй, сайн эрүүл мэндийн нэвтрүүлэг бэлдэхийн тулд дээрх шаардлагуудыг хангасан байх ёстой. Түүнээс гадна сэдэв сонголт оновчтой, эх сурвалж тэнцвэртэй бөгөөд баттай, бүтэц зохиомж сонирхолтой, ур чадварын өндөр түвшинд, хүртээмж болон үр нөлөө сайтай байхад тухайн телевизийн удирдлагаас эхлээд сэтгүүлч, хөтлөгч, нэвтрүүлийн баг хамт олон онцгой анхаарал хандуулах хэрэгтэй.

Дээрх зурвасхан ажиглалтаас үзэхэд ихэнхи телевизийн эрүүл мэндийн сэдэвт нэвтрүүлгэд нийтлэг зарим дутагдлууд байна. Тухайлбал, сэдвийн хувьд явцуу байна. Таргалалт, хавдар, эрхтнүүдийн өвчлөл, гоо сайхан, эрүүл хооллолт, эмэгтэйчүүд гэх мэтчилэн нийтлэг хэдэн жижүүрийн сэдвүүдэд эргэлдэж байна. Нийгмийн эрүүл мэндэд түүний дотор иргэ-



*Нийгмийн эрүүл мэндэд түүний дотор иргэний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сэдэвт нэвтрүүлгүүд үгүйлэгдэж байна. Мөн хүний эрүүл мэндийн салшгүй нэг хэсэг болох сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн сэдвийг бага хөндөж байна. Түүнчлэн урдчилан сэргийлсэн, асуудал дэвшүүлсэн, арга замыг эрэлхийлсэн даацтай, нийтлэл нэвтрүүлэг ховорджээ. Нийтийн эрүүл мэндийг сайжруулах, ялангуяа бага болон өсвөр насныханд тусгайлан зориулсан хөтөлбөр, нэвтрүүлэг өдрийн од шиг байна*



ний эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн сэдэвт нэвтрүүлгүүд үгүйлэгдэж байна. Мөн хүний эрүүл мэндийн салшгүй нэг хэсэг болох сэтгэл зүй, сэтгэцийн эрүүл мэндийн сэдвийг бага хөндөж байна. Түүнчлэн урдчилан сэргийлсэн, асуудал дэвшүүлсэн, арга замыг эрэлхийлсэн даацтай, нийтлэл нэвтрүүлэг ховорджээ. Нийтийн эрүүл мэндийг сайжруулах, ялангуяа бага болон өсвөр

насныханд тусгайлан зориулсан хөтөлбөр, нэвтрүүлэг өдрийн од шиг байна. Телевиз нь хэдийгээр хамгийн хүртээмжтэй мэдээллийн хэрэгсэл мөн боловч хүртээмжийг сайжруулах чухал ойлголт болох тохиромжтой цагаар тогтмол хүргэх, энгийн ойлгомжтой байдлаар өгүүлэх асуудалд учир дутагдалтай хандаж байна. Нэвтрүүлгийн цагаар зар суртчилгаа ихээр гаргах нь үзэгчдийн анхаарлыг сарниулах, нэвтрүүлгийн үр өгөөжид сөргөөр нөлөөлж байна. Ихэвчлэн ярилцлага, сурвалжлага мэдээлэл зөвлөгөө хэлбэрээр хийгдэх нэвтрүүлгүүдэд сэтгүүлчийн үүрэг роль бага байна. Энд мөн ур чадварын асуудал яригдана. Зочноо удирдан чиглүүлэх, эфир болон үзэгчтэйгээ харьцах чадвар хангалтгүй байна. Сэтгүүлч, хөтлөгч нь өөрөө тухайн сэдэв асуудлын олон талын өргөн мэдлэгтэй байх гэсэн шаардлага чухал гэдгийг мартаж болохгүй.

**Т**елевизийн эрүүл мэндийн сэдэвт нэвтрүүлгийг хэлбэр, агуулгын хувьд цаашид улам боловсронгуй болгох нь чухал юм. Оросын “НТВ” телевизийн сэтгүүлч, тоймч Леонид Парфёнов “Телевизийн нэвтрүүлэгт үзэгчид үзэж байна эсвэл үзэхгүй байна гэсэн хоёр л шалгууртай. Тэднийг үзүүлэхийн тулд бүх зүйл нь сонирхолтой байх ёстой” хэмээн хэлсэн байдаг.<sup>5</sup> Телевизийн аливаа нэвтрүүлэгт үзэгчдэд сонирхолтой байх гэсэн гол шаардлага тавигддаг. Үүний тулд Talk Show хэлбэрээр явуулж болно. Энэ нь телевизийн аль ч төрлийн нэвтрүүлэгт тохиромжтой хэлбэр гэж үздэг бөгөөд хөтлөгч үзэгчидтэйгээ шууд амьд харилцаа үүсгэн харилцан ярилцах хэлбэрээр явагддаг. Talk Show гэдэг нь Америк нэр томъёо. Их британид үүнийг Chat

show гэж нэрлэдэг. Talk Show гэдгийг утгачилбал яриан үзүүлбэр гэсэн үг юм.<sup>6</sup> Энэ нь нийтийн хэлэлцүүлгийн нэвтрүүлгийн төрөл зүйл учраас эрүүл мэндийн салбарт буй болохгүй бүтэхгүй асуудлаар үзэгчид, шинжээч, зочин, мэргэжилтнүүд зэрэг тал талын эх сурвалжуудыг оролцуулан хийх бүрэн боломжтой. Нэвтрүүлгийн танхимд өрнөх яриа нь онол, шинжлэх ухаан гэхээсээ илүү хувь хүмүүсийн амьдралын туршлага дээр үндэслэгддэг тул үзэгчдийн сонирхол татахуйц байдаг. Ток шоунд сэдвийн хувьд хязгаарлалт байхгүй тул улс төр, нийгэм, ёс зүй, эрүүл мэнд гэх мэт. Харин тухайн сэдэв нь хэт ерөнхий байх нь зохимжгүй юм. Тиймээс эрүүл мэнд дотроо дасгал хөдөлгөөн, цэвэр агаар, зөв хооллолт, хорт зуршлаа хаях, стресс гэх мэт нийгмийн эрүүл мэндийг сайжруулах, урдчилан сэргийлэхэд чиглэсэн нэвтрүүлгүүдийг ток шоу хэлбэрээр хийж болно.

Мөн үзэгчдийн мэдлэг боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн, сургалтын чанартай эрүүл мэндийн нэвтрүүлгийг эдүтэйнмент (edutainment) хэлбэрээр хийх нь сонирхолтой бөгөөд үр өгөөжтэй. Энэ нь education-entertainment гэсэн хоёр үгний нийлэмж юм. Сургалтыг хөгжилтэй, зугаатай аргаар явуулна гэсэн ерөнхий утгыг агуулж, телевизийн нэвтрүүлгийн нэг шинэ төрөл болон хөгжиж байна. Анх 1970-аад оны үеэс АНУ, Англи, Латин америкийн зарим орнуудад нийгмийн боловсролыг дээшлүүлэхэд голлон ашиглаж иржээ. ДОХ-оос хэрхэн өөрийгөө хамгаалах вэ, насанд хүрээгүй охидыг жирэмслэлтээс сэргийлэх нь, дархлааг бий болгох зэрэг сэдвүүдийг иргэдэд хялбар ойлгомжтой болгох зорилгоор сургалтын нэвтрүүлгийг

цэнгээнт хэлбэрээр зохион байгуулж гаргах болсон.<sup>7</sup>

**Э**рүүл мэндийн сэдвээр бичих гэж буй сэтгүүлч мэдээлэл хайх, боловсруулах, нийтлэн гаргах явцдаа дараах хэдэн зүйлийг зайлшгүй анхаарвал зохистой юм. Үүнд:

1. Сэдвээ сонгохоосоо өмнө тухайн мэдээ мэдээлэл олон нийтэд хэрэгтэй юу, эсвэл хэсэг бүлгийн эрх ашигт нийцэх үү гэдгийг дэнслэх.
2. Энэ мэдээллийг хэрэв би үзсэн бол, манай гэрийнхэн, ойр дотны хүнд хүрсэн бол яаж хүлээж авах вэ гэж төсөөлөн бодох.
3. Эх сурвалжийн баттай эсэхийг ямагт нягтлах.
4. Тэнцвэртэй мэдээлэл хүргэхийн тулд олон эх сурвалжтай харилцах.
5. Өөрөө салбарын мэдлэг дутмаг бол зайлшгүй мэргэжлийн хүний зөвлөгөө авах, шинжээчээр хянуулах.
6. Сэтгэлийн хөдлөл, үзэл бодлоо илэрхийлсэн өнгө аяс оруулахгүй байх.
7. Дүрс болон зургийн агуулга олон нийтэд таагүй сэтгэгдэл төрүүлэхгүй байх.
8. Эм, эмчилгээний нарийн зөвлөгөө зааврыг зайлшгүй мэргэжилтний үгээр дамжуулан хүргэх зэрэг болно.

Эцэст нь хариуцлага бас дахин хариуцлага гэж хэлмээр байна. Брюссельд төвтэй Олон улсын сэтгүүлчдийн холбооны 1954 оны Их хурлаас баталж, 1986 оны Их хурлаас шинэчлэн засварласан “Сэтгүүлчдийн баримтлах зарчим” хэмээх ОУСХ-ны тунхаг бичгийн 5 дахь заалтанд “Аль нэг хэвлэгдсэн зүйл хор тарихуйц хуудуутай болох нь нотлогдвол түүнийг засч залруулахын тулд сэтгүүлч бололцоотой бүхнийг хийнэ” гэж заасан

байдаг ч эрүүл мэндийн сэтгүүлч алдаа гаргах эрхгүй юм. Учир нь тухайн сэтгүүлч буруу мэдээлэл хүргэсний уршгаар хүний амь нас хохирвол засч залруулах ямар ч бололцоогүй нь туйлын үнэн юм.

### Ишлэл

- <sup>1</sup> Зулькафиль. М. “Сэтгүүл зүй ба дөрөв дэх засаглал”. Сэтгүүл зүй. УБ.2004. №21. х.8.
- <sup>2</sup> <http://mongolmed.mn/article/1368>
- <sup>3</sup> Наранжаргал.Х. Телевизийн сэтгүүл зүй. УБ. 2006. х.22.
- <sup>4</sup> Болд-Эрдэнэ Б. “Сэтгүүл зүйн дөрвөн онол дахь хүний тухай асуудал” // Сэтгүүл зүй ЭШБ. УБ 2007. №7. х. 32.
- <sup>5</sup> Мэндхүү.Г, Өнөрсайхан.Т. Мэргэжлийн телевиз. УБ. 2015. х. 8.
- <sup>6</sup> Наранжаргал.Х. Телевизийн сэтгүүл зүй. УБ. 2006. х.92.
- <sup>7</sup> Мэндхүү.Г, Өнөрсайхан.Т. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ. 2014. х. 152.

### Ашигласан бүтээлийн жагсаалт

1. Болд-Эрдэнэ Б. 2007. “Сэтгүүл зүйн дөрвөн онол дахь хүний тухай асуудал” Сэтгүүл зүй. №7.УБ.
2. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2014. Телевизийн тухай А-Я хүртэл. УБ.
3. Мэндхүү Г., Өнөрсайхан Т. 2015. Мэргэжлийн телевиз. УБ.
4. Наранжаргал Х. 2003. Телевизийн сэтгүүл зүй. УБ.
5. Зулькафиль. М. 2004. “Сэтгүүл зүй ба дөрөв дэх засаглал”. Сэтгүүл зүй. №21. УБ.
6. <http://mongolmed.mn/article/1368>

### Abstract

The article discusses about how Mongolian televisions considering health issues through their program. The author researched several television health programs and made appropriate conclusions. She also sought the ways how to improve television's health programs.